



СЭЛЭНГЭ АЙМАГ  
ЖАВХЛАНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 04 сарын 21 өдөр

Дугаар А/72

Жаргалант

“Ковид -19”-ын халдвараас урьдчилан  
сэргийлэх “Амны хаалтаа зүүцгээ” аяныг  
өрнүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, түүний нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 “а”, гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, Улсын Онцгой комиссын 2020 оны 04 дүгээр сарын 11-ны өдрийн 09 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2020 оны 04 дүгээр сарын 14-ны өдрийн А/119 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Ковид -19”-ын халдварын болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх ажлыг чангатгах зорилгоор “Амны хаалтаа зүүцгээ” аяныг сумын хэмжээнд 2020 оны 4 дүгээр сарын 14-ний өдрөөс 05 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд зохион байгуулсугай.
2. “Амны хаалтаа зүүцгээ” аяныг хэрэгжүүлэн, хяналт тавьж ажиллахыг сумын Хэсгийн төлөөлөгч дэслэгч /П. Буяндэлгэр/, сумын Онцгой комиссын орлогч дарга /Ж.Хүрэлбаатар/, Байгаль орчны хяналтын улсын байцаагч /Д.Төрбат/, Ерөнхий боловсролын дунд сургуулийн захирал /Н.Чимэд-очир/ нарт тус тус даалгасугай.
3. Аяны хүрээнд амны хаалтаа зөв зүүж “Ковид -19”-ын халдвараас урьдчилан сэргийлж, Гамшгаас хамгаалах тухай хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхийг нийт иргэдэд уриалсугай.

ЗАСАГ ДАРГА



Ж.ОТГОНДАЛАЙ